



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2020.01.20 № 01/161
танай 2020.01.10 -ны № 01/74 -Т

Санал хүргүүлэх тухай

“Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарын төсөл”-ийн баримт бичигтэй танилцлаа. Орхон аймаг, Эрдэнэт хотын хувьд бүсийн тэргүүлэх аймаг, хот бөгөөд Хангайн бүсийн тулгуур төв хотын нэг билээ. Мөн УИХ-аар баталсан үндсэн хуулийн өөрчлөлтөөр улс болон орон нутгийн зэрэглэлтэй хот гэдэг статусыг баталснаар хөгжих өргөн боломж бүрдсэн гэж үзэж байгаа юм.

Иймд хотын ирээдүйн хөгжлийн чиг хандлагад шаардлагатай дараах саналуудыг тусгаж өгөхийг хүсье.

д/д	Бодлогын хувилбар	Орхон аймаг, Эрдэнэ хотын санал
1	Зорилт 8.5 Хангай-Хөвсгөлийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хүн төрөлхтний цэнгэг усны нөөцийг хамгаалсан, хөрш орон, олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, аялал жуулчлал, эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн зохистой хослол бүхий бүс нутаг болгон хөгжүүлнэ.	..Хариуцлагатай уул уурхай, аялал жуулчлал, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий ногоон хот... нэмж тусгах
2	Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл I үе шат /2020-2030/	... Эрдэнэт хотод Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн паркард тулгуурласан Шинжлэх ухаан, технологи, инновацийн төв байгуулах
Зорилт 8.5.-д зорилтын хүрээнд		
3	2. Мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулах	... Эрдэнэт хотод аялал жуулчлал болон тээврийн ложистик төв байгуулах.
4	4. Уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцөд түшиглэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах	... Эрдэнэт хотод ХАА-н бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулах.
5	5. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, байгаль экологийн, тусгай сонирхлын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх	...Айргийн гозгор болон Эрдэнэт үйлдвэр түшиглэсэн Уул уурхайн аялал жуулчлал хөгжүүлэх.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ